



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард кредит ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 10 /арав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 280.000.000 /хоёр зуун наян сая/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Ард кредит ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 10 /арав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 210,000,000 /хоёр зуун арван сая/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэхүү тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 35,000,000 /гучин таван сая/ ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар тус бүрийн үнийг 70 /дал/ - 85 /наян тав/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Ард кредит ББСБ” ХХК /Ч.Ганзориг/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 35,000,000 /гучин таван сая/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 70 /дал/ төгрөгөөр “Ард кредит ББСБ” ХХК-ийн тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид худалдахыг зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын 3, 4-т заасан нийтэд санал болгон худалдаалах хувьцааны 70 /дал/ ба түүнээс дээш хувийг анхдагч зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцох бөгөөд худалдагдаагүй үлдсэн хэсгийг хүчингүйд тооцохыг “Ард кредит ББСБ” ХХК /Ч.Ганзориг/-д мэдэгдсүгэй.

6. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын 2, 4-т заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.


8. Энэ тогтоолын 5-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Ард капитал групп ҮЦК” ХХК /Б.Өлзийбаяр/-д анхааруулсугай.

9. “Ард кредит ББСБ” ХХК нь нээлттэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Ард кредит ББСБ” ХХК /Ч.Ганзориг/-д үүрэг болгосугай.

10. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Ард капитал групп ҮЦК” ХХК /Б.Өлзийбаяр/, “Өмгөөллийн И Эл Си” ХХН /Б.Баяр/, “Далайван аудит” ХХК /Ц.Жигдэн/, “БДО Аудит” ХХК /Г.Баянмөнх/-д тус тус анхааруулсугай.


11. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /М.Өлзийбат/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 01 дүгээр сарын 02-ний
өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны эзэмшлийн хувь
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	169,472,000	60.53%
2	С.Гэрэлтуяа	26,672,000	9.53%
3	В.Баяржаргал	13,856,000	4.95%
	Нийт дүн	210,000,000	75%